



ЭРДЭСТ ЧУЛУУН ХӨВӨН ДУЛААН ТУСГААРЛАГЧ

BASALTWOOL

Үндэсний Брэнд, Эко-Үйлдвэрлэгч



шүрилдэг
БАЗАЛТВҮҮЛ



Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн дулаалга нь хэрэглэхэд хялбар түргэн хугацаанд ажлыг гүйцэтгэх боломжтой ба газар доорх авто зогсоол, олон төрлийн хоолойг байрлуулсан тааз, цэнгэлдэх хүрээлэнгийн хөнгөн болон олон төрлийн хэлбэртэй дээвэр, нисэх онгоцны буудлын дээвэр, ган багана зэрэг ажиллахад түвэгтэй хэсгийг шүршиж дулаалах, дуу чимээ тусгаарлах, галын аюулаас хамгаалахад тохиромжтой материал юм.

- Ашиглахад хялбар: ажлыг гүйцэтгэхэд хялбар, үр дүнтэй богино хугацаанд хийж болно
- Бүх төрлийн гадаргуу дээр ашиглаж болно: архитектурын олон шийдэлтэй, ажиллахад төвөгтэй гадаргуу дээр шүршиж болох ба ажилчид хүрч чадахгүй хэсгүүдэд хэрэглэхэд тохиромжтой.
Тохиромжтой гадаргуу: ган, бетон, модон гадаргууд хэрэглэж болно мөн усны хамгаалалттай гипсэн хавтан дээр хэрэглэхэд тохиромжтой.

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнг бэлтгэх технологи, шинж чанар, хэрэглэх газар, тоног төхөөрөмж, технологийн процесс, анхааруулга.

А. Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнг бэлтгэх технологи.

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн нь хоёр төрлийн орцоос бүрдэнэ. Орцод Базальтвүүл чулуун хөвөн, байгаль орчинд хоргүй усан суурьтай холбогч цавууг хэрэглэнэ. Эдгээр орцыг шүршигч машинаар шүрших бөгөөд байшин барилгын дулаалах гадаргуу, хөлөг онгоц, галт тэрэг зэргийг дулаалж болно. Дулаалсан гадаргууг ердийн дулаанд хатаах ба нягт, бат бөх, тодорхой зузаантай болдог. Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн нь дулаан хадгалах, дуу чимээ тусгаарлах, галын аюулгүй, мөгөөнцөрт тэсвэртэй хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй зэрэг сайн шинжийг өөртөө агуулдаг.



Б. Ашиглалтын шинж чанар.

- Ердийн дулаан тусгаарлах материал (шилэн хөвөн, хөөсөнцөр хавтан) –ийн залгаасаар зай завсар, хэлбэрээ алдах, хурдан хуучирч муудах, унах, зэрэг дутагдлууд гардаг бол, шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн ажиллахад хялбар бөгөөд дулаагыг чанартай сайн бологдог.

В. Хэрэглэх газар.



- Барилга: модон барилга, орон сууцны барилга, зочид буудал, бүх төрлийн цэнгэлдэх хүрээлэн, спорт зал, төмөр замын буудал, кино театр, музей, үзэсгэлэнгийн төв, их дэлгүүр, үйлдвэр, нисэх онгоцны буудлын барилгууд

4 Шүршдэг Базальтвүүл

дээр дулааны болон дуу чимээ, галаас хамгаалах тусгаарлагч болгон хэрэглэнэ.

■ Төмөр зам: метроны буудлын ган каркас, төмөр замын дуу чимээ, галын болон дулааны тусгаарлагчаар ашиглана.

■ Нүхэн гарц: гарцны дотор талд галаас хамгаалах, дулааны болон дуу чимээний тусгаарлагч болгон хэрэглэнэ.



Г. Шүршигч машин.



Базальтвүүл чулуун хөвөн шүршигч машин нь G-1500, DELTA VFD-M загварынх байдаг ба ашиглагдах талбайгаас хамаарч сонгоно. Шүршигч машины үзүүлэлтийг дараах хүснэгтээс үзнэ үү


Д. Технологийн дараалал.

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн, барьцалдуулагч цавуу хоолойн хошуугаар холигдож



Загвар	Тодорхойлолт (хэмжээ: мм)	Шүршигчийн хүчин чадал	Сэнсний Чадал кВт	Шүрших Хэлбэр
		Чулуун хөвөн		
G-1500	Иж бүрэн шүрших машин 1150*600*1150	5/8	3@2200w/220v	зөөлөн
VFD-M	Хөвөнг бутлаж, шүрших машин 1550*850*950	5/8	2@1400w/380v	зөөлөн





өндөр даралттайгаар гадаргуу дээр шүршигдэн бөх бат жигд гадаргуу үүсгэж дулаан, дуу чимээний тусгаарлагч болж өгнө. Ингэж жигд шүршигдсэнээр ховхрох, хагарч, завсар гардаггүй.


Е. Анхааруулга.

а. Базальтвүүл чулуун хөвөнг шүрших үедээ шүршигч машиныг тохируулна үүнд хөвөн гарах хэмжээ, үлээгч, шахуурга, зэргийг гарын авлагад заасны дагуу хэр хэмжээний хөвөн, холбогч цавуу ямар хэмжээтэй хэрэгтэйг тогтооно. Шалгасны дараа ажиллуулж эхэлнэ.

б. Хэрэвээ хөвөн шүрших гадаргуугаас ус гоожиж байвал ажлыг үргэлжлүүлэхгүй.

с. Цацахаасаа өмнө барьцалдуулагч бодисыг цацах талбайд шингэрүүлэн цацаж Базальтвүүл чулуун хөвөнг шүршинэ.

д. Дууссаны дараа үлдсэн наалдамхай бодисыг гадаргуу дээр цацаж өгнө.



Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнгийн хэрэглээ.

А. Дулаан сайн тусгаарлагч.

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн нь дээд зэргийн дулаан тусгаарлагч материал юм. Дулаан хадгалалтыг хэмжихэд дулаан дамжуулалтын итгэлцүүр нь 0.038 Вт/м °С хүртэл хадгалах боломжтой нь туршилтаар нотлогдсон бөгөөд энэ нь тусгайлсан хэв загвартай бүтцэд сайн тусгаарлагч болж өгөх боломжтой. Сайн барьцалдаж ямар нэг залгаагүйгээр бат бөх давхарга үүсдэг нь хүйтэн, халууныг нэвтрүүлэхгүй сайн тусгаарлагчийн үүрэг гүйцэтгэдэг.

Б. Дуу чимээ шингээн, ус чийг нэвтрүүлэхгүй.

А. Дуу чимээ сарниулах

Базальтвүүл чулуун хөвөнг шүршисэний дараа бүтцэд байдаг шөрмөслөгүүд нь хоорондоо барьцалдан нийлмэл гурван хэмжээст бөх, хатуу бүтцийг үүсгэдэг. Дууны долгион хөвөнг чичиргэснээр акустик энергийг механик энергид шилжүүлнэ. Шилжүүлэх хугацаа уртассанаар акустик энергийг сулруулж дууг сарниулж шингээнэ. Базальтвүүл чулуун хөвөнгийн дуу чимээ бууруулах коэффициент нь 30Дб.

Б. Дуу чимээг тусгаарлана.

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнг жигд шүршсэнээр тасалгаа хоорондын дуу чимээ, дээвэр дээр бороо орж байхад гарах дуу чимээ зэргийг алга болгоно.

В. Галын аюулгүй байдал.

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөн материалыг ашигласнаар галын аюулаас хамгаалагдах ба эко бүтээгдэхүүн юм. Барилгын материалын шатах хэв шинжийн EN60695-11-20 стандартаар ОБЕГ-ын Гамшиг судлалын хүрээлэнгийн ШҮ галд шатдаггүй ангилалд ордог.

Г. Хүрээлэн буй орчинд ээлтэй.

■ Базальтвүүл чулуун хөвөн шүршдэг дулаалгын орц нь базальт чулуунаас гаргаж авсан хөвөн, усан суурьтай барьцалдуулагч цавуунаас бүрдэнэ. Эдгээр материал нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын

стандарт шаардлагыг хангасан байдаг.

■ Базальтвүүл чулуу хөвөн дулаалгын материал нь Монгол улсын MNS-EN13162-2011 стандартыг хангасан бүтээгдэхүүн юм.

■ Барьцалдуулагч материал нь GB18583-2001 “Гадаад засал чимэглэл, наалдамхай материалын аюулгүй хэмжээ” стандартыг бүрэн хангасан.

■ Базальтвүүл чулуун хөвөн нь хөгц, мөөгөнцөр үүсдэггүй бүтээгдэхүүн юм.

Д. Бусад.

Чийгтэй гадаргууд шууд хэрэглэх боломжтой бөгөөд гадаргууг янз бүрийн өнгө гаргаж болно. Чулуун хөвөнгийн үзэмжийг дээшлүүлэх, засал чимэглэлийн зориулалтаар хэрэглэж болно. Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнгийн РН үзүүлэлт нь 6-7 бөгөөд бетон, ган материалд ашиглахад зэвэрдэггүй.



Бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт.**Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнгийн физик, химийн үзүүлэлт.**

Химийн найрлага (масс%)					
SiO ₂	Al ₂ O ₃	CaO	MgO	MnO	Fe ₂ O ₃
42,4	13,36	26,73	2,78	0.163	6,96
Физик үзүүлэлт					
Нягт дээд хэмжээ (кг/м³)	Органик агууламж	Хөвөнгийн диаметр (мкм)	Хөвөнгийн шаваасын түвшин (≤ 0.25 мм)	Өнгө	
120	≤ 0.2%	≤ 5.0	≤ 5%	Ногоон	

Шүршдэг Базальтвүүл чулуун хөвөнгийн давхаргын үзүүлэлт.

Зүйл	Нэгж	Хөвөнгийн давхарга	Шалгасан стандарт
Хөвөнгийн харагдах байдал		Гадаргуу саарал, жигд, жигд хагарал үүсээгүй	Нүдээр харах
Нягт (хатсан)		120±10	MNS-EN 13162-2011
Чимээ багасгах коэффициент	Чимээг намсгах коэф	0.80	EN ISO 11654
Дулаан нэвтрүүлэх чанар	Вт/м°C	≤0.038	MNS ISO 29475-2010
Шатах байдал	Ангилал	Шатдаггүй ШҮ	EN 60695-11-20
Бэхжилт		≥ 1.7	MNS-EN 13162-2011
РН	Кра	6-7	EN 16534







вэб хуудас:
www.rockwool.mn

ХАЯГ:
ТӨВ ОФФИС
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваний
өргөн чөлөө, "Фламинго Тауэр"- 7 давхар
Улаанбаатар хот, Монгол
Утас: +(976)-95951068
Факс: +(976)-11331058
и-мэйл: enkhgerel@rockwool.mn

ҮЙЛДВЭР
Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн
тойруу-132, Үйлдвэрийн баруун бүс,
Улаанбаатар хот, Монгол
Утас: +(976)-99076694, 99076695
+(976)-70170208
и-мэйл: monbasalt@rockwool.mn